

БАТЛАВ.
КРЕДО ТЕРРА ХХК-ИЙН ЗАХИРАЛ



О.МӨНХБАДРАЛ

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

Худалдах, худалдан авах гэрээ

2017 оны 4-р сарын 11-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

2017 04 12 006

Энэхүү гэрээг нэг талаас 5237421 регистрийн дугаартай Кредо Терра ХХК, түүнийг төлөөлж Захирал О.Мөнхбадрал (цаашид “Худалдагч” гэх), нөгөө талаас Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Захиргаа, санхүү, үйлчилгээний албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Оюунчимэг (цаашид “Худалдан авагч” гэх) бид дараах зүйлсийг харилцан тохиролцож байгуулав.

1. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү гэрээнд заасны дагуу Худалдагч нь биет байдал, эрхийн доголдолгүй H-Info 3.0 системийн эх код болон холбогдох бусад програм хангамж, веб сайт, хүний нөөц, сарын тайлангийн систем /цаашид “Бүтээгдэхүүн” гэх/-ийг Худалдан авагчид хүлээлгэн өгөх Худалдан авагч нь бүтээгдэхүүнийг хүлээн авч гэрээнд заасны дагуу төлбөрийг төлнө.
- 1.2. Худалдагч бүтээгдэхүүнд холбогдох аливаа баримт, бичгийг Худалдан авагчид хүлээлгэн өгнө.
- 1.3. Худалдагч нь энэхүү гэрээний Хавсралтад дурдсан жагсаалтын дагуу бүтээгдэхүүнийг Худалдан авагчид хүлээлгэн өгсөн байна.

2. Баталгаат хугацаа

- 2.1. Баталгаат хугацаа нь Худалдан авагчид бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 3 сарын хугацаатай байна.
- 2.2. Худалдан авагч нь баталгаат хугацаанд хүлээлгэн өгсөн бүтээгдэхүүнтэй холбогдон гарах аливаа асуудлыг тодруулахаар тайлбар, нэмэлт мэдээллийг Худалдагчаас авах эрхтэй.

3. Иж бүрдэл

- 3.1. Худалдагчийн нийлүүлэх бүтээгдэхүүний иж бүрдлийг энэхүү гэрээний Хавсралтад дурдсанаар тодорхойлно.

4. Хүлээлгэн өгөх хугацаа, нөхцөл

- 4.1. Худалдагч нь гэрээнд заасан бүтээгдэхүүнийг Худалдан авагчид 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр хүлээлгэн өгнө.
- 4.2. Бүтээгдэхүүнийг Худалдагч нь энэхүү гэрээний Хавсралтад заасан нөхцөлийн дагуу Худалдан авагчид хүлээлгэн өгнө.

5. Үнэ төлбөр

- 5.1. Бүтээгдэхүүний нийт үнийн дүнг 27.500.000 /хорин долоон сая таван таван зуун мянга/-н төгрөг байхаар талууд харилцан тохиролцсон. /энэхүү үнийн дүнд НӨАТ багтсан болно./
- 5.2. Худалдан авагч нь бүтээгдэхүүнийг хүлээж авсан өдрөөс хойш Худалдагчийн гаргаж өгсөн нэхэмжлэхийг үндэслэн гэрээний нийт үнийн дүнгийн 50 хувь буюу 13.750.000 /арван хоёр сая таван зуун мянга/-н төгрөгийн төлбөрийг төлнө.
- 5.3. Бүтээгдэхүүнийг бүрэн хүлээн авч, талууд акт үйлдэж гэрээг дүгнэсний эцэст Худалдагч талын нэхэмжлэхийг үндэслэн үлдэгдэл 50 хувь буюу 13.750.000 төгрөгийн төлбөрийг төлнө.
- 5.4. Үнэ нэмэх, валютын үнэ унах зэрэг нь энэхүү гэрээний нийт үнийг өөрчлөх үндэс болохгүй.

6. Бүтээгдэхүүнийг хүлээн авах

- 6.1. Худалдагч нь Худалдан авагчид Эрүүл мэндийн хөгжлийн төвийн байранд бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгнө.

7. Гэрээний хүчин төгөлдөр байдал

- 7.1. Энэхүү гэрээ талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Энэхүү гэрээ нь үүргийг бүрэн гүйцэтгэх хүртэл хүчин төгөлдөр байх боловч аль ч тохиолдолд 2017 оны 7 дугаар сарын 03-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

8. Талуудын үүрэг хариуцлага

- 8.1. Хэрэв аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ гэрээний хүчин төгөлдөр хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлэхээс татгалзвал, нөгөө талдаа гэрээний нийт үнийн дүнгийн 20 хувийн торгууль төлнө.
- 8.2. Худалдагч тал бүтээгдэхүүнийг гуравдагч этгээдэд худалдан борлуулахыг хатуу хориглоно.
- 8.3. Худалдагч тал бүтээгдэхүүнийг хувьдаа ашиглах, эзэмших болон гуравдагч этгээдэд ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно.
- 8.4. Гэрээний 8.2-8.3 дахь хэсэгт заасныг Худалдагч тал зөрчсөн бол гэрээний дагуу болон хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

9. Давагдашгүй хүчин зүйл

- 13.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

10. Маргаан шийдвэрлэх

- 10.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монгол Улсын шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

11. Гэрээнд нэмэлт өөрчлөлт хийх

- 11.1. Энэхүү гэрээний нөхцлийг талуудын хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан баримт бичгийн дагуу өөрчилж болно.

11.2. Талууд нөгөө талын зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй.

12. Талуудын хоорондох харилцаа

12.1. Талуудыг төлөөлж дараах этгээдүүдэд энэхүү гэрээтэй холбоотой асуудлаар харилцаа холбоо тогтоож, хэлэлцээ хийнэ:

Худалдагчийн төлөөлөгч: О.МӨНХБАДРАЛ

Утас: 99668899

Худалдан авагчийн төлөөлөгч: Статистик, мэдээлэл технологийн албаны дарга Х.Ганцэцэг, Төслийн зохицуулагч М.АМАРТОГТОХ

Утас: 99098083, 88068508

13. Бусад нөхцөл

13.1. Энэхүү гэрээ хоёр хувь үйлдэгдэх бөгөөд талуудад нэг нэг хувь хадгалагдана.

13.2. Монгол Улсын Иргэний хуулиар энэхүү гэрээнд дурдаагүй асуудлыг зохицуулна.

13.3. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээний өмнөх хэлэлцээр, харилцаа холбоо, зөвлөмж, санал хүчингүй болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

КРЕДО ТЕРРА ХХК-ИЙН ЗАХИРАЛ


ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРГАА, САНХҮҮ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



КРЕДО ТЕРРА ХХК
КРЕДО ТЕРРА
LLC
5287421 ХАК7946
УЛААНБААТАР ХОТ

О.МӨНХБАДРАЛ

Л.ОЮУНЧИМЭГ



4456 9086331

2017.04.11